

(Түрүүч нь 1992 оны № 3-4-д бий)

31. **Гувер, Герберт Кларк** (1874— 1964) Айова муж улсын Уэст-Бранг хотод төрсөн. 1895—1913 он хүртэл Австри, Энэтхэг, Өмнөд Африк, Хятад, Сибирьт уул уурхай, төмөрлөгийн үйлдвэр, төмөр замд инженерээр ажиллаж байв. Тэр дэлхийн I дайны төгсгөлийг түргэтгэхэд оролцсон мянга мянган америкчуудад дайны төлбөр төлөх хороо байгуулахыг санаачилсан юм. Чухамхүү энэ байгууллагаас Г. Гуверийн улс төрийн үйл ажиллагаа эхэлжээ. Тэр 1917 оноос АНУ-ын цэргийн хүнсний яам, 1921—1928 онд худалдааны яамны сайдаар ажиллаж байв. 1928 онд Бүгд Найрамдах (хойшид БНН) намаас ерөнхийлөгчийн сонгуульд нэрээ дэвшүүлж «цэцэглэн хөгжих» лоозон дэвшүүлж ялсан. 1932 оны VI сард Женевийн бага хуралд Америкийн төлөөлөгчид дэлхийн хэмжээнд зэвсэг хорогдуулах, тухайлбал бөмбөгдөгч онгоцыг бүхэлд нь танк, хүнд зэвсэг хорогдуулах, бүх төрлийн химийн зэвсгийг устгах, их гүрнүүд зэвсэгт хүчнээ доод төвшинд байлгах тухай санал оруулсан юм. АНУ-ын энэ саналыг «Гуверийн бөмбөг» гэж нэрлэсэн байна.

32. **Рузвельт, Франклин Делано** (1882---- 1945) Нью-Йорк муж улсын Хойд Парк хотод газрын том эзний гэрт төрсөн. Тэр Гротонскугийн язгууртны дунд сургууль, Гарвардын Их сургууль, Колумбын Их сургуулийн хуулийн анги төгссөн. 1905 онд ерөнхийлөгч Теодор Рузвельтийн ач охин (зээ) Элеоноре Рузвельттэй гэрлэсэн. Тэрээр 1907— 1910 онд Нью-Йоркийн томоохон фермд хуулийн мэргэжилтнээр ажиллаж байгаад уг мужид болсон Ардчилсан Намын (хойшид АН) их хуралд төлөөлөгчөөр сонгогдсон удалгүй мөн ондоо муж улсын сенатад сонгогдож 1912 онд дахин сонгогдсон. 1913-1916 онд Тэнгисийн яамны сайдын туслахаар томилогдсон. Дэлхий I дайны дараа улс төрийн ажиллагаагаа идэвхжүүлж 1920 онд АН-аас дэд ерөнхийлөгчид нэрээ дэвшүүлсэн боловч ялагдсан. 1921 оноос хүнд өвчнөөр удтал өвдөж улс төрийн үйл ажиллагаанаас нэг хэсэг хөндийрсөн боловч 1924—1928 онд Нью-Йорк муж улсын захирагчаар сонгогдон ажиллахдаа дэвшилт нэлээд арга хэмжээ авч хэрэгжүүлж байлаа. 1932 онд АН-аас ерөнхийлөгчийн сонгуульд нэрээ дэвшүүлж БНН-ын Гувертэй өрсөлдөж ялалт байгуулсан. 1936, 1940, 1944 онд АНУ-ын ерөнхийлөгчөөр дахин сонгогдож байсан нь америкийн түүхэнд хамгийн олон удаа сонгогдсон ерөнхийлөгч болсон юм. Тэр ерөнхийлөгч болоод 1929—1933 оны дэлхийн эдийн засгийн хямралын өөрийн улсад ноогдох уршгийг арилгахын тулд эдийн засагт «шинэ эргэлтийн» бодлого гэдгийг явуулсан нь үлэмж үр дүн, хүрсэн. Бас түүнийг АНУ-ын гадаад бодлогод хамгийн уян хатан зарчим баримталсан хүн гэж үнэлдэг. Чухамхүү тэрээр ерөнхийлөгч болсон анхныхаа жилд ЗХУ-ыг анх удаа хүлээн зөвшөөрч дипломат харилцаа тогтоосон юм.

И. В. Сталин 1934 онд Гэнри А. Уэльстэй ярилцахдаа: «Ф. Д. Рузвельт бол орчин үеийн капиталист ертөнцийн бүх капитануудын дотроос хамгийн хүчтэй, гол зүтгэлтэн болох нь ямар ч эргэлзээгүй юм» гэжээ. Тэр америкийн түүхэнд ул мөрөө гүн үлдээсэн юм. Тэрээр фашизмтай хамтран ажиллах нь АНУ-д аюултай гэж ойлгох, дэлхийн II дайн эхлэхэд фашизмын эсрэг тэмцэлд Англи, Францад тусламж үзүүлэхээ илэрхийлж байлаа. Ф. Рузвельт зөвлөлтийн эсрэг америкийн зарим хүчнийхний байр суурийг буруушааж ЗХУ-д лендлизийн шугамаар тусламж үзүүлэхийг хамгаалсан юм. Дэлхийн II дайнд АНУ нэгдэн

орсны дараа (1941 оны ХП сар) гитлерийн эсрэг эвслийг байгуулахад чухал үүрэг гүйцэтгэсэн. Мөн 1942 оны Зөвлөлт-Америкийн хэлэлцээр, Тегеран, Ялтын гурван гүрний бага хурал зэрэгт АНУ-ыг тэргүүлж оролцсон Ф. Рузвельт НҮБ-ыг байгуулах нь дайны дараах олон улсын харилцааг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой гэж үзэж байв. Дайны дараа ЗХУ-тай хамтын ажиллагаагаа хөгжүүлэн бэхжүүлэх нь бүх нийтийн аюулгүй байдлыг хангах нэн чухал нөхцөл гэж хэлсэн нь чухамдаа түүний улс төрийн гэрээслэл байв.

Ф. Рузвельт гитлерийн германыг бууж өгөхөөс хэдхэн долоо хоногийн өмнө учир битүүлэг шалтгаанаар нас баржээ.

33. Трумэн, Гарри (1884—1972) Миссури муж улсын Ламар хотод фермийн эзний гэр бүлд төрсөн. Тэрээр хууль цаазны дунд сургууль төгсөж, эцгээсээ өвлөж авсан ферм дээр амьдралаа эхэлжээ. Дэлхийн I дайнд АНУ-ын цэрэгт албан хааж Францад морин цэргийн сумангийн дарга байгаад 1919 онд халагдаж, хувийн дэлгүүрийн эзнээр ажиллаж байв. 1926-1934 онд Миссури муж улсын тойргийн шүүхийн дарга. 1934 онд конгресст сонгогдож сенатч болсон. 1940 онд дахин сонгогдсон. 1945 оны 1 сараас АНУ-ын дэд ерөнхийлөгч, 1945 оны IV сараас АНУ-ын ерөнхийлөгч болсон (ф. Рузвельтийг нас барахад оронд нь). Түүний сенатч байхдаа «Хэрэв Гитлер дийлж байвал бид Орост туслах ёстой. Хэрвээ орос дийлж байвал бид Германд туслах ёстой. Гэхдээ ямар ч нөхцөлд Гитлер ялахыг би хүсэхгүй боловч тэд бие биеэ аль болохоор их хядалцаг» гэж хэсэг нь түүхэнд тэмдэглэгдсэн билээ. 1945 оны VII сард гурван гүрний Потсдамын бага хуралд АНУ-ын төлөөлөгчдийг тэргүүлэн оролцсон. VIII сард Японы Хиросима, Нагасаки хотод атомын бөмбөг хаях тушаалд гарын үсэг зурсан.

II дайны дараа Г. Трумэн Зөвлөлтийн эсрэг, коммунизмын эсрэг «хүчээр түрээ барих» «хүйтэн дайны» бодлогыг явуулсан юм. 1945 онд «коммунизмыг номхотгох» номлол дэвшүүлж, 1949 онд НАТО болон цэргийн бусад эвслийг байгуулж, Солонгост дайн хийв. Дотоод бодлогын хувьд нийгмийн өргөн бодлого явуулна гэж амласан боловч хоосон үг болж үлджээ.

Г. Трумэний үед америкийн зарим хүчин, ялангуяа америкийн коммунист намын эсрэг үйл ажиллагаа явуулж байлаа. Амьдралынхаа сүүлийн жилүүдэд олон улсын харилцаа. АНУ-ын гадаад бодлого, түүний дотор Зөвлөлт-Америкийн харилцаанд хандахад зарим бодит үзэл бодол илэрхийлж байв.

34. Эйзенхауэр, Дуайт Дейвуд (1890—1969) Техас муж улсын Денисон хотод төрсөн 1915 онд цэргийн академи төгссөн. 1920 оноос АНУ-ын Цэргийн яам, Армийн штабт ажиллаж байв. 1942 оны VI сараас Европ дахь америкийн цэргийн командлагч, 1943 оноос Өрнөд Европ дахь холбоотон гүрний Цэргийн дээд ерөнхий командлагчаар ажиллаж Европт П фронт нээгдэхэд (1944) Нормандад англи-америкийн цэргийг буулгах ажлыг удирдсан юм. Фашист Германыг бут цохисны дараа Герман дахь АНУ-ын эзэмшлийн бүсийн цэргийн ерөнхий командлагчаар ажиллаж байв. 1945—1948 онд АНУ-ын Армийн штабын дарга, 1948—10 онд Колумбын Их сургуулийн ректор. 1950-1952 онд Европт НАТО-гийн зэвсэгт хүчний дээд ерөнхий командлагч, 1952 оны ерөнхийлөгчийн сонгуульд БНН-аас нэрээ дэвшүүлэн ялж 1953—1961 онд АНУ-ын ерөнхийлөгчөөр ажиллаж байв.

Д. Эйзенхауэр 1945 оны VIII сард И В. Сталинтай ярилцахдаа түүний дэлхийн шинэ дайн гаргуулахгүйн тулд бүхнийг хийх нь чухал гэсэн саналыг нь халуунаар зөвшөөрч байгаагаа илэрхийлж байжээ. Гэтэл Д.Эйзенхауэрийн үед л ЗХУ, социалист орнуудын эсрэг дэлхийн шинэ дайны төлөвлөгөөг боловсруулсан байна. Бүр 1945 онд Европ дахь АНУ-ын эзэмшлийн цэргийн ерөнхий командлагч байхдаа түүний

оруулсан «Тоталити» гэгч төлөвлөгөөнд ЗХУ-д атомын 20 цохилт өгөхөөр заажээ. Сайхь төлөвлөгөөний улс төрийн гол зорилго нь ЗХУ болон түүний холбоотнуудыг бут ниргэх замаар «Большевизмийг үр үндсээр нь устгах» ёстой байжээ. АНУ-ын үндэсний аюулгүй байдалд хамгийн ноцтой занал учруулж байгаа зүйл нь... социалист байгууллын мөн чанар юм» гэж тэр төлөвлөгөөнд тэмдэглэсэн байна.

Д. Эйзенхауэрийг ерөнхийлөгч байх үед 1957 онд дэгдээхээр бэлтгэсэн дэлхийн шинэ дайны хөтөлбөр болох «Дропшотын» төлөвлөгөө ёсоор ЗХУ болон социалист бусад орны эсрэг 30 хоногийн дотор 100 атомын бөмбөг хэрэглэж америк-английн хамтарсан агаарын операц явуулах ёстой байжээ.

35. Кеннеди, Жон Фицджералд (1917—1963) Массачусетс муж улсын Бруктайн хотод саяхны гэр бүлд төрсөн. Лондоны эдийн засгийн сургууль. Гарвардын их сургуулийн хуулийн анги төгссөн. 1941—1945 онд Номхон далай дахь АНУ-ын тэнгисийн цэргийн флотод алба хааж. 1945—1947 онд сэтгүүлчээр ажиллаж байв. 1947—1953 онд төлөөлөгчдийн танхимын гишүүн, 1953—1960 онд сенатч, 1961—1963 онд АНУ-ын ерөнхийлөгч байлаа. 1961 оны VI сард Австрийн Вена хотноо Н. С. Хрушевтэй уулзсан юм. 1963 оны XI сард Далласт алагдсан.

Гадаад бодлогодоо «уян хатнаар угтан хариулах» чиг шугамыг тунхаглаж, АНУ цэргийн хүчин чадал, Өрнөдийн цэргийн эвслийг бэхжүүлж «коммунизмыг тогтоон барих»-д эдийн засаг, үзэл суртлын хэрэгслийг өргөн ашиглахыг уриалж байлаа.

1961 онд Кубад хувьсгалын эсэргүүцүүдийг хүчээр оруулахыг зөвшөөрч, 1962 онд Карибын тэнгисийн хямралын үеэр гол үүрэг гүйцэтгэсэн. Цаашдаа ЗХУ-тай харилцахдаа бодит байр сууринаас хандаж байсан юм. 1963 онд Агаар мандал, сансрын уудам, усан дор цөмийн туршилт хийхийг хориглох тухай гэрээ байгуулахыг дэмжсэн. Ер нь 1960-аад оноос АНУ социалист орнуудын цэрэг-улс төрийн хүчин чадал өсөн нэмэгдсэнийг харгалзан ЗХУ-тай пуужинт цөмийн сөргөлдөөн хийх нь осолтой гэдгийг хүлээн зөвшөөрсөн юм. Тэр цагаас хойш АНУ хойчийн дайны хамгийн магадтай хэлбэр нь «хязгаарлагдмал цөмийн дайн» гэж үзсэн байна.

36. Жонсон Линдон (1908—1973) Техас муж улсын Стонуолл хотын ойролцоо төрсөн. 1930 онд Багшийн коллеж төгсөөд багшилж байв. 1939—1948 онд Конгресст төлөөлөгчдийн танхимын гишүүн, 1949—1961 онд Конгресст сенатч, мөн 1953-1961 онд АН-ын тэргүүн байлаа. 1961 оноос АНУ-ын дэд ерөнхийлөгч 1963 онд алагдсан ерөнхийлөгч Дж. Кеннедийн оронд АНУ-ын ерөнхийлөгч болсон. Тэрээр Техасын санхүү-аж үйлдвэр, нефтийн бүлэглэлийнхэнтэй нягт хамтран ажиллаж байв. Түүний үед АНУ-ын гадаад бодлого илэрхий интервенционист шинжтэй болсон билээ. Вьетнамд дайн хийж, 1965 оны IV сард Бүгд Найрамдах Доминикан улсад цэргийн хунтад тусалж, мөн тэр жил АНУ-ын Зэвсэгт хүчний оролцоотойгоор Конгод Үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнийг дарж, 1967 онд Ойрхи Дорнодын хямралын үеэр Изриалийг идэвхтэй дэмжсэн юм.

37. Никсон, Ричард Милхаус. 1913 онд Калифорни муж улсын Иор ба-Линдо хотод төрсөн. 1934 онд коллеж, 1937 онд Дьюксын Их сургуулийн (Умард Каролины) хуулийн анги төгссөн. 1937—1942 онд өмгөөлөгч, 1942 оноос Засгийн газрын онцгой арга хэмжээг хэрэгжүүлэх газар ажиллаж дараа нь АНУ-ын тэнгисийн цэргийн хүчинд алба хаасан. 1946—1950 онд төлөөлөгчдийн танхимын гишүүн, 1950—1953 онд сенатч, 1953—1961 онд Дэд ерөнхийлөгч 1960 онд БНН-аас ерөнхийлөгчийн сонгуульд нэрээ дэвшүүлсэн боловч ялагдсан. 1961—1968 онд Калифорни муж улсад өмгөөлөгчөөр ажиллаж байв. 1968 онд ерөнхийлөгч, 1972 онд дахин сонгогдож 1974 он хүртэл ажиллаж байгаад Уо-

тергейтын будлианаас болж огцорсон. 1972 оны V сард ЗХУ-д албан ёсны айлчлал хийж хүрээлэн байгаа орчныг хамгаалах, анагаах ухаан, эрүүлийг хамгаалах, сансрын уудмыг энх тайвны зорилгоор ашиглах салбарт хамтран ажиллах, агаарын болон далай тэнгист будлианыг зайлуулах хэлэлцээрт; пуужингаас эсэргүүцэн хамгаалах системийг хязгаарлах талаар гэрээ; стратегийн давшилтын зэвсэглэлийг хязгаарлах зарим арга хэмжээний тухай түр хэлэлцээр; ЗХУ-АНУ-ын хамтын ажиллагааны үндсэн баримт бичигт тус тус гарын үсэг зурсан. 1973 оны VI сард Л. И. Брежневтэй Вашингтон хотноо хэлэлцээ хийсэн. 1974 оны VII сард ЗХУ-д 2 дахь удаагаа албан ёсны айлчлал хийж Зөвлөлтийн удирдлагатай хэлэлцээ хийсэн, Р. Никсон одоо Нью-Жерси муж улсын Садл-Ривер хотод амьдарч байна. Тэрээр Францын урлагийн академийн сурвалжлагч гишүүнээс гадна «Лос-Анжелес таймс», «Санди таймс» сонины улс төрийн тоймчоор ажиллаж байна.

38. Форд. Жеральд Рудольф. 1913 онд Небраск муж улсын Омаха хотод жижиг үйлдвэрийн эзний гэр бүлд төрсөн 1935 онд Мичиганы Их сургууль, 1941 онд Иелийн Их сургуулийн хуулийн факультетийг төгссөн. 1942—1946 онд АНУ-ын тэнгисийн цэргийн хүчинд алба хаасан. 1946-1948 онд мэргэжлийнхээ дагуу ажиллаж 1948—1973 онд төлөөлөгчдийн танхимд БНН-ынхныг тэргүүлж байв. 1973 оны X сард АНУ-ын дэд ерөнхийлөгч, 1974 оны VIII сард ерөнхийлөгч Р. Никсоныг огцроход түүний оронд ерөнхийлөгч болсон. Ж. Фордын үед АНУ-ын гадаад бодлогод эвийг эрхэмлэх хандлага тодорхой харагдсан юм. 1974 оны XI сард Владивостокт Л. И. Брежневтэй ажлын уулзалт хийсэн. 1975 оны VIII сард Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны тухай зөвлөлгөөний төгсгөлийн баримт бичигт Хельсинк хотноо гарын үсэг зурсан. Түүнийг ерөнхийлөгч байх үед 1975 оны зун -Зөвлөлт Америкийн сансрын хамтарсан нислэг (Союз-Аполлон) болсон билээ. 1976 оны ерөнхийлөгчийн сонгуульд ялагдсаны дараа Өмнөд Каролин муж улсын Пали-Спринг хотод суурьшжээ. Одоо их, дээд сургуульд лекц уншин «Чартер ойл» хэмээх нефтийн компанийн зөвлөгч, «Американ экспресс» компанийн удирдлагын зөвлөлийн гишүүнээр ажиллаж байна.

39. Картер Жеймс (Жимми) Эрл. 1924 онд Жорж муж улсын Плейнс хотод төрсөн. 1941—1943 онд Технологийн дээд сургууль, 1946 онд Тэнгисийн цэргийн академи төгссөн. 1953 он хүртэл АНУ-ын тэнгисийн цэргийн хүчинд алба хаасан. 1953—1962 онд Жорж муж улсын томоохон фермд ажиллаж 1962-1966 онд энэ муж улсын хууль тогтоох хуралд сенатч, 1971—1975 онд Жорж муж улсын захирагчаар ажиллаж байв. 1976 оны ерөнхийлөгчийн сонгуульд ялсан. 1979 оны VI сард зөвлөлтийн удирдагч Л. И. Брежневтэй Австрийн Вена хотноо стратегийн давшилтын зэвсэглэлийг хязгаарлах 2 дахь гэрээнд гарын үсэг зурсан. Гэвч К. Картер «хүчээр түрээ барих» номлолыг дахин тунхаглаж, 70-аад оны олон улсын намжмал байдал, Зөвлөлт - Америкийн харилцааг хэвийн болгох бодлогоос татгалзаж «хүйтэн дайны» бодлогыг сэргээсэн юм.

Түүний ерөнхийлөгч байх үед 1978 оны V сард болсон НАТО-гийн зөвлөлийн чуулган эвслийн орнуудын цэргийн зардлыг жил бүр эрс нэмэгдүүлэх шийдвэр гаргасан. 1979 онд НАТО-гийн Брюсселийн чуулганаар Итали, Англи, Бельги, Голландад Америкийн дунд тусгалын Першинг—2 болон «Томагавк» 572 цөмийн далавчит пуужинг байрлуулахаар шийдвэрлэсэн юм. Тэр Персийн буланг Америкийн «амин чухал эрх ашгийн бүс» хэмээн зарлаж мөн Кэмп-Дэвидийн (1979 он) салангид хэлэлцээрийн гол удирдагч байлаа.

1980 оны ерөнхийлөгчийн сонгуульд ялагдаж төрсөн нутгийн зүг

жолоо залсан. Одоо дээд сургуульд түүх, улс төр, хууль эрх зэрэг хичээл зааж байна. 1982 онд профессор болжээ.

40. Рейган, Рональд Уильсон. 1911 онд Иллинойс муж улсын Томпико хотод гутлын худалдаачны гэр бүлд төрсөн.

Р. Рейган 1920 онд дунд сургууль. 1932 онд Юрика хотын (Иллинойс муж) Коллежийг эдийн засаг, социологчийн мэргэжлээр төгсөөд Де-Мойнд спортын тоймчоор ажиллаж, удалгүй Голливудын нэрт кино компани «Уорнер бразерс»-тэй холбоо тогтоож 1937 онд анх удаа кино дэлгэцнээ гарчээ. Нийтдээ уран сайхны 54 кинонд тоглосон. Кинонд ажиллаж байхдаа жүжигчин Жейн Уаймантай танилцаж гэрлэсэн боловч 1948 онд салсан. 1952 онд Нэнси Дейвистэй гэрлэсэн Нэнси бол Рейганы улс төрийн тавцанд дэвшихэд гол үүрэг гүйцэтгэсэн хүн юм.

II дайны үед АНУ-ын зэвсэгт хүчинд алба хаасан. 1947-1952, мөн 1959 онд кино жүжигчдийн ҮЭ-ийн хөдөлгөөнд идэвхтэй оролцож уг хөдөлгөөний ерөнхийлөгчөөр сонгогдож байв. 1954 онд «Женерал электрик» компанийн томоохон телепрограмм «Театр женерал электрик» нэвтрүүлэгтэй гэрээ хийж ажилласан. 1962 оноос «Боракс» хэмээх санхүүгийн компанийн телевизийн долоо хоног тутмын нэвтрүүлгийн нэрт тайлбарлагч болсон. 1964 онд БНН-ын баруун жигүүрийн тэргүүн байв. 1960-аад оноос улс төрийн тавцанд дэвшиж эхэлжээ. 1965 онд Калифорни муж улсын захирагч, 1970 онд хоёр дахь удаагаа сонгогдож дараа нь 1975—1979 онд улс төр, хэвлэл нийтлэлийн ажлыг идэвхтэй явуулж БНН-д чухал үүрэг гүйцэтгэж байв. 1980 онд ерөнхийлөгч болж, 1984 онд хоёр дахь удаагаа ялсан. 1982 онд социализмын эсрэг загалмайтны аян дайн хийхийг уриалж, 1983 онд «Оддын дайн»-ы программыг дэвшүүлсэн юм.

Р. Рейган 1985 онд Женевт 1986 онд Рейкявкт Зөвлөлтийн удирдагч М. С. Горбачевтай хэлэлцээ хийж 1987 онд Вашингтонд дунд болон ойр тусгалгай пуужинг устгах тухай гэрээнд гарын үсэг зурсан. 1988 онд Москвад албан ёсны айлчлал хийсэн юм. Түүнийг ерөнхийлөгч байх үед Монгол-Америкийн хооронд дипломат харилцаа (1987.1.27) тогтоожээ.

Р Рейган одоо Калифорни муж улсын Лос-Анжелес хотоос холгүй Номхон далайн эрэг дээр орших 2,5 сая долларын өртөгтэй хувийн байшиндаа тухлан сууж байна. 1989 оны XI сард Америкийн сагсан бөмбөгийн оддуудын тэмцээний тайлбарлагчаар ажилласан байна.

41. Буш, Жорж Герберт Уокер. Массачусетс муж улсын Мигтон хотод 1924 онд төрсөн. Ж. Буш Андовер хотын эрх ямбатнуудын хувийн сургууль. Филиппсийн академийг тус тус төгссөн. 1942 онд сайн дураараа цэрэгт явж АНУ-ын тэнгисийн цэргийн нисэх хүчинд алба хаасан. 1942 онд Өмнөд Каролинд нисэхийн сургуульд сурч байхдаа Барбара Пирстэй гэр бүл болжээ.

1945—1948 онд Иэлийн их сургуулийн эдийн засгийн факультетийг онц дүнтэй төгссөн. Дараа нь Техас муж улсын нефтийн аж үйлдвэрийн «Дрессер индастриз» компанид ажиллаж байв. 1954—1964 онд Техасын хоёр томоохон компанийн ерөнхийлөгч, 1964-1966 онд эдгээр компанийн захирлуудын зөвлөлийн бүрэлдэхүүнд орж байжээ. 1966-1970 онд Техас муж улсаас конгрессийн төлөөлөгчдийн танхимын гишүүнээр сонгогджээ. 1970—1973 онд НҮБ дэх АНУ-ын Байнгын төлөөлөгч, 1973—1975 онд БНН-ын Үндэсний хорооны дарга, Бээжинд АНУ ын холбоо барих бүлгийн удирдагч, 1975—1977 онд тагнуулын төв газрын захирал, 1976—1980 онд Техасын хоёр банк, нэг химийн үйлдвэрийг нэгтгэсэн ерөнхий хорооны гишүүнээр ажиллаж байгаад ерөнхийлөгч Р. Рейганы (1980—1988) үед АНУ-ын дэд ерөнхийлөгч, 1988-1992 онд АНУ-ын ерөнхийлөгч байв.

1989 оны ХП сард Мальтад, 1990 оны V сарын сүүлчээр Вашингтонд Зөвлөлтийн удирдагч М. С. Горбачевтой хэлэлцээр хийж байв.

42. **Билл Клинтон.** 1946 оны VШ сарын 19-нд Арканзас муж улсын Хоупн хэмээх газар төржээ. Түүний анхны нэр Уильям Жефферсон Блайт IV хэмээх боловч хойд эцгийнхээ нэрээр хожим Клинтон болжээ. 1964 онд дунд сургууль дүүргээд, 1964—1973 онд Жорж Тауны их сургууль, Оксфордын их сургууль, мөн Йелийн их сургуулийг хуулийн мэргэжлээр төгссөн байна. Тэрээр 1976 онд төрсөн нутаг Арканзас муж улсынхаа ерөнхий прокуророор сонгогдож, 1978 онд мөн муж улсынхаа захирагч болжээ. 1980 онд муж улсынхаа захирагчийн сонгуульд ялагдсан боловч 1982, 1984, 1986, 1990 онд Арканзас муж улсын захирагчаар удаа дараалан сонгогджээ. Клинтон 1992 онд АНУ-ын ерөнхийлөгчийн сонгуульд АН-аас нэр дэвшин ялж тус улсын 42 дахь ерөнхийлөгч болов.